



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.26 № 01/164
танай _____ -ны № _____ -г

НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ
ДҮҮРГИЙН ХҮҮХЭД, ГЭР
БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.БИЛГҮҮН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Налайх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 314,143.5 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн хүрээнд эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн төслийг боловсруулахдаа тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг судалж, нөхцөл байдал, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор

02003633

C:\Users\zendmene.d\Desktop\2026\Word\Yvian\2025.02.25.HD.HSBI.HI.docx

мэдээлэл байршуулаагүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 93.6 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75,981,282.27</u>	<u>89,196,853.00</u>
33	АВЛАГА	00.00	427,565.00
335	Бусад авлага	00.00	427,565.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	427,565.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,981,282.27	88,769,288.00
351	Түүхий эд материал	10,503,223.27	9,466,889.00
35110	Тусгай зориулалттай материал	10,503,223.27	9,466,889.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	473,510.00	575,000.00
354	Хангамжийн материал	65,004,549.00	78,727,399.00
35410	Бичиг хэргийн материал	850,000.00	19,940,800.00
35420	Аж ахуйн материал	11,181,400.00	3,247,500.00
35470	Бусад хангамжийн материал	52,973,149.00	55,539,099.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,805,639,062.31</u>	<u>2,769,957,490.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,805,639,062.31	2,769,957,490.09
392	Биет хөрөнгө	2,729,640,062.31	2,693,958,490.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,959,379,624.55	2,982,105,624.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-435,566,892.23	-510,081,848.51
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,000,000.00	28,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,666,666.30	-28,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,163,758.00	218,998,758.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-68,494,798.42	-97,737,614.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	133,867,375.00	134,867,375.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,325,453.11	-58,680,544.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,995,000.00	29,995,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,711,885.18	-5,508,260.14
393	Биет бус хөрөнгө	75,999,000.00	75,999,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	75,999,000.00	75,999,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,881,620,344.58</u>	<u>2,859,154,343.09</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,881,620,344.58</u>	<u>2,859,154,343.09</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,881,620,344.58	2,859,154,343.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	65,249,010.00	65,249,010.00
51101	Өмч: - төрийн	65,249,010.00	65,249,010.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,816,371,334.58	2,793,905,333.09
51210	Өмнөх үеийн үр дүн	2,816,371,334.58	2,816,371,334.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-22,466,001.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,881,620,344.58</u>	<u>2,859,154,343.09</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
-----	----------	----------	------------

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,117,784,068.27	1,273,974,947.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,690,363.27	54,840,728.51
120	Нийтлэг татварын бус орлого	10,690,363.27	54,840,728.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	9,736,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	9,736,000.00
120009	Бусад орлого	776,074.27	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	37,016,666.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,914,289.00	8,088,062.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,107,093,705.00	1,219,134,219.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	558,670,600.00	917,732,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	558,670,600.00	917,732,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	548,423,105.00	301,401,619.00
131103	ЭГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,900,000.00	39,820,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,401,305.00	139,159,119.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,121,800.00	122,422,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,046,327,736.22	1,296,440,949.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,046,327,736.22	1,296,440,949.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	945,433,181.22	1,212,943,368.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,079,621.00	478,336,635.00
210101	Үндсэн цалин	231,720,149.49	285,910,129.00
210102	Нэмэгдэл	38,837,339.66	115,858,406.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,848,648.85	39,390,000.00
210104	Урамшуулал	48,673,483.00	37,178,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,129,284.00	58,397,400.00
210201	Тэтгэврийн даатгал	34,320,035.99	39,710,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,772,366.31	4,671,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,940,718.05	2,335,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	645,213.45	2,336,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,450,950.20	9,343,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,771,940.00	53,002,009.00
210301	Гэрэл, цахилгаан	13,819,230.00	11,110,620.00
210302	Түлш, халаалт	39,350,244.00	38,166,393.00
210303	Цэвэр, бохир ус	4,602,466.00	3,724,996.00

2104	Хангамж, бараа материалын зардал	57,549,880.00	63,785,036.27
210401	Бичиг хэрэг	28,127,040.00	38,059,550.00
210402	Тээвэр, шатахуун	10,731,090.00	8,623,446.27
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,797,400.00	2,025,000.00
210404	Ном, хэвлэл	0	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,674,000.00	2,160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,220,350.00	10,917,040.00
2105	Нормативт зардал	17,462,795.00	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	264,400.00	0
210502	Хоол, хүнс	17,198,395.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,190,650.00	27,678,000.00
210604	Урсгал засвар	8,190,650.00	27,678,000.00
2107	Томилолт, зочны зардал	0	455,500.00
210702	Дотоод албан томилолт	0	455,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,411,960.82	297,669,899.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,718,960.82	296,378,489.00
210803	Даатгалын үйлчилгээ	72,000.00	97,910.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	70,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	25,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	621,000.00	1,098,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,837,050.40	233,618,888.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,139,005.00	114,382,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,800.00	227,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,487,245.40	119,009,238.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,894,555.00	83,497,581.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,604,400.00	65,910,466.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	42,005,126.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	22,691,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,604,400.00	1,214,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,290,155.00	17,587,115.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,488,655.00	17,587,115.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,801,500.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	71,456,332.05	-22,466,001.49
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	623,700.00	0

145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	623,700.00	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	45,863,017.69	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	45,863,017.69	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,217,014.36	-22,466,001.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,107,093,705.00	1,228,870,219.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,736,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	9,736,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	9,736,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,736,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,107,093,705.00	1,219,134,219.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	558,670,600.00	917,732,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	558,670,600.00	917,732,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	548,423,105.00	301,401,619.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,900,000.00	39,820,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,401,305.00	139,159,119.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,121,800.00	122,422,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	913,919,654.99	1,182,559,219.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	913,919,654.99	1,182,559,219.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	813,025,099.99	1,099,061,638.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,079,620.99	478,764,200.00
210101	Үндсэн цалин	231,720,149.48	286,337,694.00
210102	Нэмэгдэл	38,837,339.66	115,858,406.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,848,648.85	39,390,000.00
210104	Урамшуулал	48,673,483.00	37,178,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,129,284.00	58,397,400.00
210201	Тэтгэврийн даатгал	34,320,035.99	39,710,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,772,366.31	4,671,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,940,718.05	2,335,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	645,213.45	2,336,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,450,950.20	9,343,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,771,940.00	53,002,009.00

**Нийслэлийн Налайх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210301	Гэрэл, цахилгаан	13,819,230.00	11,110,620.00
210302	Түлш, халаалт	39,350,244.00	38,166,393.00
210303	Цэвэр, бохир ус	4,602,466.00	3,724,996.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,202,090.00	34,817,000.00
210401	Бичиг хэрэг	19,820,190.00	13,623,150.00
210402	Тээвэр, шатахуун	10,457,250.00	1,317,010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,797,400.00	2,025,000.00
210404	Ном, хэвлэл	-	9,900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,674,000.00	2,160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,453,250.00	5,791,840.00
2105	Нормативт зардал	16,871,190.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	264,400.00	-
210502	Хоол, хүнс	16,606,790.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,030,450.00	47,658,500.00
210604	Урсгал засвар	13,030,450.00	47,658,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	455,500.00
210702	Дотоод албан томилолт	-	455,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,943,355.00	423,243,229.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,250,355.00	421,951,819.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	97,910.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,000.00	70,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	621,000.00	1,098,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,997,170.00	2,723,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,746,970.00	1,347,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,200.00	1,376,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,894,555.00	83,497,581.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,604,400.00	65,910,466.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	42,005,126.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	22,691,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,604,400.00	1,214,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,290,155.00	17,587,115.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,290,155.00	17,587,115.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	193,174,050.01	46,311,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	193,174,050.00	46,311,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	193,174,050.00	46,311,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	193,174,050.00	46,311,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	193,174,050.00	46,311,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(193,174,050.00)	(46,311,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.01	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	65,249,010.00		2,790,154,320.22	2,855,403,330.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,249,010.00		2,790,154,320.22	2,855,403,330.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-		26,217,014.36	26,217,014.36
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,249,010.00		2,816,371,334.58	2,881,620,344.58
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	65,249,010.00		2,816,371,334.58	2,881,620,344.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,249,010.00		2,816,371,334.58	2,881,620,344.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-		-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-		-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-		(22,466,001.49)	(22,466,001.49)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,249,010.00		2,793,905,333.09	2,859,154,343.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	917,732,600.00	909,881,485.00	7,851,115.00	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	917,732,600.00	909,881,485.00	7,851,115.00	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	851,437,900.00	844,271,019.00	7,166,881.00	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,764,200.00	478,764,200.00	-	100.0
210101	Үндсэн цалин	271,514,900.00	286,337,694.00	(14,822,794.00)	105.5
210102	Нэмэгдэл	150,504,400.00	115,858,406.00	34,645,994.00	77.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,562,500.00	39,390,000.00	(8,827,500.00)	128.9
210104	Урамшуулал	26,182,400.00	37,178,100.00	(10,995,700.00)	142.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,397,400.00	58,397,400.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	39,710,100.00	39,710,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,671,900.00	4,671,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,335,900.00	2,335,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,336,000.00	2,336,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,343,500.00	9,343,500.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,088,600.00	53,002,009.00	7,086,591.00	88.2
210301	Гэрэл, цахилгаан	13,931,200.00	11,110,620.00	2,820,580.00	79.8
210302	Түлш, халаалт	37,795,400.00	38,166,393.00	(370,993.00)	101.0
210303	Цэвэр, бохир ус	8,362,000.00	3,724,996.00	4,637,004.00	44.5
2104	Хангамж, бараа материалын зардал	11,263,600.00	11,263,600.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	3,943,000.00	2,318,150.00	1,624,850.00	58.8
210402	Тээвэр, шатахуун	1,834,300.00	1,173,610.00	660,690.00	64.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,834,300.00	1,980,000.00	(145,700.00)	107.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	458,600.00	-	458,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,193,400.00	5,791,840.00	(2,598,440.00)	181.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,452,500.00	22,402,500.00	50,000.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,950,000.00	50,000.00	99.8
210604	Урсгал засвар	2,452,500.00	2,452,500.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	455,500.00	455,500.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	455,500.00	455,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	218,639,400.00	218,609,110.00	30,290.00	100.0

Нийслэлийн Налайх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	217,317,700.00	217,317,700.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	98,000.00	97,910.00	90.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,600.00	70,000.00	600.00	99.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,500.00	25,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,116,400.00	1,098,000.00	18,400.00	98.4
210807	Газрын төлбөр	11,200.00	0	11,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,376,700.00	1,376,700.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,376,700.00	1,376,700.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,294,700.00	65,610,466.00	684,234.00	99.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,294,700.00	65,610,466.00	684,234.00	99.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,658,800.00	42,005,126.00	653,674.00	98.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,721,400.00	22,691,340.00	30,060.00	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	914,500.00	914,000.00	500.00	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	917,732,600.00	909,881,485.00	7,851,115.00	99.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	917,732,600.00	900,145,485.00	17,587,115.00	98.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	917,732,600.00	900,145,485.00	17,587,115.00	98.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	9,736,000.00	(9,736,000.00)	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	9,736,000.00	(9,736,000.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	41	41	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13	13	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,401,619.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,401,619.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,101,619.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,553,400.00
210401	Бичиг хэрэг	11,305,000.00
210402	Тээвэр, шатахуун	143,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,000.00
210404	Ном, хэвлэл	9,900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,567,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,265,000.00
210604	Урсгал засвар	64,302,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,634,119.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	204,634,119.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,347,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,347,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	301,401,619.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	301,401,619.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,820,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	139,159,119.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	122,422,500.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 93,803.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 84,263.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 9,540.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 93,803.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Ажлын туршлага, гүйцэтгэлийг харгалзалгүйгээр 2024 оны 02 дугаар сарын 21-нд байгуулагдсан аж ахуйн нэгжтэй 2024 оны 02 дугаар сарын 22-нд гэрээ байгуулж 11,000.0 мянган төгрөгийн судалгаа хийлгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд ажил гүйцэтгүүлэхээр аж ахуйн нэгжийг сонгохдоо өмнөх ажлын туршлага, санхүүгийн байдал зэргийг харгалзан харьцуулалт хийгээгүй зөрчлийг зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2.Барилгад урсгал засвар хийхдээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалгүй 73,263.5 мянган төгрөгийн бараа материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1 Хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой 9,540.0 мянган төгрөгийн видео бичлэг хийлгэснийг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, материалыг орлогод авч бүртгэж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Барилгад урсгал засвар хийхдээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалгүй шууд гэрээ байгуулсан.	1	73,263.5			1	73,263.5						
Ажлын туршлага, гүйцэтгэлийг харгалзахгүйгээр 2024 оны 02 дугаар сарын 21-нд байгуулагдсан ААН-тэй 2024 оны 02 дугаар сарын 22-нд гэрээ байгуулж судалгаа хийлгэсэн	1	11,000.0			1	11,000.0						
Хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой видео бичлэг хийлгэснийг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.	1	9,540.0					1	9,540.0				

Дүн	3	93,805.3			2	84,263.5	1	9,540.0				
------------	----------	-----------------	--	--	----------	-----------------	----------	----------------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	220,340.0					1	220,340.0
Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээлээгүй байна.	1						1	
"Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх" хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа хэрэгцээ шаардлагыг үндэслээгүй, суурь судалгаа, шинжилгээ хийгээгүй, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлт тодорхойлоогүй, тооцооллын хамт хүргүүлээгүй байна.	1						1	
Дүн	3	220,340.0					3	220,340.0

Нийслэлийн Налайх дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		